



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 69.

Дархан

Байгууллага байгуулах, дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2.4 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Дархан-Уул аймагт барилга байгууламж барих, засварлах, шинэчлэх, өргөтгөх ажлыг эхлүүлэх, гүйцэтгэх явцад техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж, гүйцэтгэлийг баталгаажуулах, барилга байгууламжийг хугацаанд нь ашиглалтанд оруулах зорилгоор “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” Орон нутгийн өмчит ААТҮГазрыг 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс байгуулсугай.

2. “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” Орон нутгийн өмчит ААТҮГазрын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Тус үйлдвэрийн газар байгуулагдсантай холбогдуулан холбогдох арга хэмжээг авч, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Насанбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЭРДЭНЭБАТ



**“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР” ОРОН
НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү дүрмийн зорилго нь “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлага, зэрэг харилцааг холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн зохицуулахад оршино.


1.2 “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” орон нутгийн өмчит үйлдвэрийн газар /цаашид “үйлдвэрийн газар” гэх/ нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар мөн.

1.3 Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Иргэний хууль, Засаг захиртаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Орон сууцны тухай хууль, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны тухай хууль, Нэгдсэн төсвийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль, Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2009 оны 7-р тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм” болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн энэхүү дүрмийн хүрээнд явуулна.

1.4 Үйлдвэрийн газар нь барилга байгууламж барих, засварлах, шинэчлэх, өргөтгөх, ажил /цаашид “барилгын ажил” гэх/-ыг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж эхлүүлэх, гүйцэтгэх явцад батлагдсан зураг, төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавих, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулах, материал, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг оновчтой зохион байгуулах, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулан барилга байгууламжийг цаг хугацаанд нь ашиглалтанд оруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.5 Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч, өмчлөгч нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь Засаг дарга байна.

1.6 Үйлдвэрийн газрын оноосон нэр нь “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, товчилсон нэр нь ДХББЗГ-ОНӨҮГ байх ба өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, бие даасан тайлан тэнцэлтэй, үндсэн зорилго нь орлогоороо зарлагаа нөхөж ашигтай ажиллах бөгөөд өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээнэ.



ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БЭЛГЭДЭЛ, ТЭМДЭГ

2.1. Үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагааны онцлогийг илтгэсэн бэлгэдэлтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

2.2. Тэмдгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

2.3. Тэмдгийг үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагын итгэмжлэгдсэн этгээд хариуцна.

2.4. Үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага бэлгэдэл, тэмдгийн загварыг баталж, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг эдэлнэ.

ГУРАВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Үйлдвэрийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг газрын даргын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга тогтооно.

3.2. Үйлдвэрийн газрын даргыг аймгийн Засаг дарга, бусад ажилтныг Газрын дарга тус тус томилж, чөлөөлнө.

3.3 Үйлдвэрийн газрын дарга нь аймгийн Ерөнхий архитектор байж болно.

3.4. Үйлдвэрийн газрын байнгын ажилтнууд нь ажлын байрны тодорхойлолттой байх ба ажлын онцлог, шаардлагуудыг харгалзан мэргэжлийн хүмүүсийг тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэхээр гэрээгээр ажиллуулж болно.


3.5. Үйлдвэрийн газрын дарга, ажилтнууд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудад заасан шаардлагуудыг хангасан байна.

3.6. Үйлдвэрийн газар нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт засварын ажилд захиалагчийн хяналт тавихаас гадна хувийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж байгаа иргэн, хуулийн этгээдийн барилгын гүйцэтгэлд гэрээний үндсэн дээр захиалагчийн хяналт гүйцэтгэж болно.

3.7. Зураг төсөл захиалах түүнд хяналт хийх, холбогдох байгууллагуудын зөвшөөрөл авах, төрийн захиалгаар тодорхой хэмжээний зураг төсөв хийх эрхтэй байж болно.

3.8. Үйлдвэрийн газар нь барилга, барилгын материалын чанарт хяналт тавих лаборатори /тоног төхөөрөмж/ барилга байгууламжийн технологийн тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга, зүгшрүүлэлт, түүн дээр ажиллах мэргэжлийн ажилчдыг сургаж дадлагажуулах зорилго бүхий сургалтын баазтай байж болно.

3.9 Үйлдвэрийн газрын дарга, ажилтнууд нь захиалагчийн хяналт тавьж буй барилга, объектын гүйцэтгэгч байж болохгүй.



3.10 Үйлдвэрийн газрын ажилтнууд нь газрын даргын өмнө ажлаа тайлагнах үүрэгтэй.

3.11 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 3-р ангилалын барилга байгууламжууд засварын ажлуудад барилгын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтанд оруулах ажлыг зохион байгуулж ажиллах ба шаардлагатай нөхцөлд барилгын ажлын зураг төсөл, угсралтын ажилд барилгын зохих хууль дүрэм норм, стандартын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтантай зөвшилцөж өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулна.

3.12 Хувийн болон Төрийн бус байгууллагуудын барилга угсралтын ажлыг эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах, барилга байгууламжийг Улсын комисс хүлээн авах хүртэл ажилд зөвлөх үйлчилгээг үзүүлж болно.

ДӨРӨВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Тус үйлдвэрийн газрын дарга нь аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулсны үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах ба дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1 Холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төлөөлөх

4.1.2 Үйлдвэрийн газрыг төлөөлж гэрээ, хэлцэл байгуулах

4.1.3 Үйлдвэрийн газрын үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах,

4.1.4 Үндсэн хөрөнгийг өмчлөгчөөс олгосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах,


4.1.5 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас хуульд заагдсан татвар хураамжийг төлсний дараах цэвэр ашгийг зохих журмын дагуу захиран зарцуулах

4.1.6 Үйлдвэрийн газрын ажилтуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, тэдгээрийг томилох чөлөөлөх,

4.1.7 Эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч, сангийн хэмжээнд ажилтнуудын цалинг тогтоох,

4.1.8 Санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтлүүлэн, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистик мэдээ тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах,

4.1.9 Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үүний тулд үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх заавар, журам гаргаж биелэлтийг хангуулах,



4.1.10 Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан аливаа нууцыг задруулахгүй байх, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх,

4.1.11 Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, шагнаж урамшуулах, тэдний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх талаар тодорхой төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх,

4.1.12 Гүйцэтгэгч, Туслан гүйцэтгэгч, Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, болон бусад этгээдтэй байгуулсан гэрээг дүгнэх,

4.1.13 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.

4.2 Үйлдвэрийн газрын дарга өөрийн эрх, үүргийг итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно.

4.3 Батлагдсан бүтэц орон тоонд нийцүүлэн ажилтануудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, сэлгэн ажиллуулах.

4.4 Өөрийн эрх хэмжээний хүрээнд үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдсон үйлдвэрийн зохион байгуулалт, техникийн асуудлыг шийдвэрлэх

4.5 Үйлдвэрийн газрын дарга нь эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана.

ТАВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТ, САНХҮҮГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАН

5.1 Орон нутгийн төсвийн болон улсын төсвөөс орон нутагт эрх шилжүүлсэн хөрөнгө, оруулалтын зардлын төсөвт тусгагдсан техник хяналтын ажлын зардал.

5.2 Өөрийн ажил үйлчилгээнээс олсон орлого

5.3 Банкны зээлийн эх үүсвэр

5.4 Орон нутгийн төсвийн дэмжлэг


5.5 Хууль тогтоомжоор тогтоогдсон бусад эх үүсвэр

5.6 Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

5.7 Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг дарга, нягтлан бодогч нар хариуцна.

5.8 Барилгын техник хяналтын зардлаас захиалагчид хяналтын үйл ажиллагаатай холбоотой зардалд тодорхой хэмжээний санхүүжилт олгож болно.

5.9 Үйлдвэрийн газар нь төсөвлөгдсөн зардлаас илүү гарсан үйл ажиллагааны орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлнэ.





ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 85

Дархан


Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.7 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Дархан-Хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 3 дахь хэсгийн 3.6 дахь заалтын “.... захиалагчийн хяналт тавихаас гадна” гэсний дараа “олон улсын болон зээлийн,....” гэж нэмсүгэй.

ДАРГА

Г.ЭРДЭНЭБАТ



✓



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 116

Дархан

Тогтоолын хавсралтад
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэхь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Дархан-Хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГазрын дүрэмд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсугай.

а. Гурав дахь бүлгийн 3.1 Үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргын саналыг үндэслэн Орон нутгийн өмчийн газрын дарга хянаж, аймгийн Засаг дарга тогтооно.

б. Гурав дахь бүлгийн 3.11 Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, засварын ажлуудад зохих журамын дагуу барилгын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтанд оруулах ажлыг зохион байгуулж ажиллах ба шаардлагатай нөхцөлд барилгын ажлын зураг төсөл, угсралтын ажилд барилгын зохих хууль дүрэм норм, стандартын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтантай зөвшилцөж өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулна.

в. Дөрөв дэх бүлгийн 4.1.7 Байгууллагын дарга нь тухайн жилийн үйл ажиллагааны орлогоос хамаарч, цалингийн сангийн хэмжээнд ажилтнуудын цалинг тогтоох.

г. Тав дахь бүлгийн 5.9 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас 25 хүртлэх хувийг ногдол ашиг хэлбэрээр аймгийн төсөвт төвлөрүүлнэ. Үүнийг жил бүр аймгийн Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлнэ.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Насанбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЭРДЭНЭБАТ